# Нохой, муурны карантин

**Та амьтан, малын гаралтай бүтээгдэхүүн тээж яваа бол дахин нэг бодож үзнэ үү!**

## Импортын шалгалт

### >> Карантины хугацаа

**90 хоногтой нохой, муур**

– Галзуу өвчний эсрэг вакцин хийлгээд дархлал тогтсон (30 хоног) бол: 1 өдөр
– Дархлал тогтох (30 хоног) хугацаа болоогүй бол: Дархлал тогтох хүртэл
– Вакцин тариулсан талаар холбогдох бичиг баримт байхгүй буюу вакцин хийлгээгүй бол: Вакцин хийлгээд 30 хоног

**∗ 90–ээс доош хоногтой нохой, муур**
- Вакцин хийлгэсэн, хийлгээгүй: 1 өдөр

**∗ Галзуу өвчин гардаггүй орнууд бүгд 1 өдөр**

※ Галзуу өвчин гардаггүй орнууд: Япон, Тайвань, Ирланд, Кипр, Австрали, Шинэ Зеланд, Хавай, Фижи арал, Сингапур, Португал, Исланд, Жамайка, Гуам, Самоа, Англи

### >> Дагалдах бичиг баримт

**∗ Мал эмнэлгээс вакцин хийлгэсэн тухай бичиг**
- 90–ээс доош хоногтой бол мал эмнэлгээс өгсөн эрүүл мэндийн бичиг

**∗ Урьдчилан мэдэгдэлгүйгээр оруулах боломжтой амьтны тоо: 4-өөс доош**

※ Австрали, Малайзаас оруулж байвал нэмэлт бичиг баримт шаардлагатай тул шалгалтын албад хандана уу.

## Экспортын шалгалт

### >> Карантины хугацаа: 1 өдөр

### >> Дагалдах бичиг баримт

Галзуу өвчний эсрэг вакцин хийлгэсэн тухай бичиг болон тухайн орны засгийн газар, худалдан авагчийн шаардсан бичиг баримт

※ Австрали, Шинэ Зеланд, Япон, Европ рүү экспортлох бол нэмэлт бичиг баримт шаардлагатай тул шалгалтын албад хандана уу.

# Мал, малын гаралтай бүтээгдэхүүний карантин

**Малын халдварт шүлхий, галзуу өвчин дотоодод тархахаас урьдчилан сэргийлэн энэхүү карантиныг хийж байна.**

## ▪ Мэдүүлэг өгөх амьтан, бүтээгдэхүүн –

- Нохой, муур, тэжээвэр шувуу г.м
- Бугын цусан болон хатаасан эвэр, яс г.м
- Үхэр, гахай, хонь, тахианы мах, хиам, борц, консерв, чанасан мах г.м
- Сүү, бяслаг, масло г.м
- Өндөг болон өндөгний төрлийн зүйлс

## ▪ Үхэр, гахай, хонь, тахиа, галууны мах, хиам авч яваа бол –

Солонгост ирэх → Шалган нэвтрэх → Тээшний мэдүүлэг өгөх → Үзлэгт орох → Гаалийн шалгах → Нэвтрэн орох

**Та малын гаралтай бүтээгдэхүүн авч яваа бол тээшне ий мэдүүлэг бөглөж, мал эмнэлгийн байцаагчид хандаж, заавал үзлэгт орохыг хүсье!**


**ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ**
УЛСЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
www.nvrqs.go.kr УТАС: +82-2-1588-9060

# Тахианы халдварт томуу

Тахианы томуу өвчин нь тахиа, галуу, цацагт хяруул г.м шувуудад илэрдэг өвчин юм. Тахианы томуу нь үхэлд хүргэх аюултай өвчин тул тухайн оронд халдварлан орж ирсэн тохиолдолд маш их хэмжээний гарз хохирол учруулах, хүний генийг өөрчлөн улмаар хүнээс хүнд халдварлан "шинэ төрлийн томууны вирус" болон хувирах аюултай.

## Тархалтын зам-

Нүүдпийн шувууд, гадаадын аялагчдын тээж яваа бүтээгдэхүүнээс тархаж болно. Мөн өвчтэй тахиа, галууны ялгадас, тоос шороо, хувцас, гутал, машин зэргээр дамжин халдварладаг.

## Тахианы томуу гардаг орнуудын амьтан, малын гаралтай бүтээгдэхүүний карантин-

**Тахианы томуу гардаг орнуудын амьтан, малын гаралтай бүтээгдэхүүнийг импортлох хатуу хориотой!**

Хятад, Тайланд, Вьетнам, Индонез, Камбож г.м орнуудаас тахиа, галууны мах, бүтээгдэхүүнийг авч ирэх боломжгүй. Хэрэв авч ирэх бол мал эмнэлгийн байцаагчид мэдэгдэнэ үү.

## Шувууны махыг импортлох боломжтой орнууд -

Импортын барааны ариун цэврийн шаардлага хангасан бичиг баримтыг мэдүүлэх ёстой.

※ Тухайн орны иргэд мал эмнэлгийн байцаагчид хандана уу.

## Тахианы томуу гарсан Азийн орнууд руу аялах гэж буй иргэдэд -

Өвчний халдварлалтыг багасгах үүднээс тахианы фермээр очихгүй байх, санаандгүй өвчний голомтод очсон бол нутагтаа ирээд доод тал нь 14 хоног мал аж ахуйн ферм дээр очихгүй байхыг зөвлөж байна.

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ**
УЛСЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
www.nvrqs.go.kr УТАС: +82-2-1588-9060

# Малын халдварт шүлхий

Халдварт шүлхий өвчин нь үхэр, гахай, ямаа, хонь, буга зэрэг хос тууе райтай амьтдын тусдаг хамгийн аюултай, маш их хэмжээний гарз хохирол учруулах халдварт өвчин юм.

## Тархалтын зам-

Малын гаралтай бүтээгдэхүүн хууль бусаар оруулах, гадаадын аялагчдын тээж яваа бүтээгдэхүүнээс тархаж болно. Өвчилсөн малын ялгадас, шүлс, сүү, ус, тоос шороо, хувцас, гутал, машин зэргээр дамжин халдварладаг.

## Халдварт шүлхий гардаг орнуудын амьтан, малын гаралтай бүтээгдэхүүний карантин-

**Халдварт шүлхий гардаг орнуудын амьтан, малын гаралтай бүтээгдэхүүнийг импортлох хатуу хориотой!**

Хятад, Монгол, Орос, Тайланд, г.м орнуудаас үхэр, гахайн мах, шийр, хиам, борц, консерв зэргийг авч ирэх боломжгүй. Хэрэв авч ирэх бол мал эмнэлгийн байцаагчид мэдэгдэнэ үү.

## Халдварт шүлхий гарсан Азийн орнууд руу аялах гэж буй иргэдэд -

Өвчний халдварлалтыг багасгах үүднээс үхэр, гахайн фермээр очихгүй байх, санаандгүй өвчний голомтод очсон бол нутагтаа ирээд доод тал нь 14 хоног мал аж ахуйн ферм дээр очихгүй байхыг зөвлөж байна. Ялангуяа аялахдаа өмсөж явсан хувцас, гутал зэргийг сайтар ариутган цэвэрлэж, гүйцэд хатаах хэрэгтэй.

**» Малын гаралтай бүтээгдэхүүн хууль бусаар оруулвал дээд тал нь 5 сая воны торгуультай!**

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ**
УЛСЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
www.nvrqs.go.kr УТАС: +82-2-1588-9060